



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2016 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/29

Улаанбаатар хот

Ажлын алба байгуулах тухай

Монгол Улсын Агаарын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Монгол Улсын 2016 оны Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.18 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Засгийн газрын 2015 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 501 тогтоол, Монгол Улсын Ерөнхий сайдын 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 151 захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын албыг татан буулгаж Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын сайдын, Цэвэр агаар санг татан буулгаж Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуулчлалын яамны мэдэлд шилжүүлсэнтэй холбогдуулан агаарын бохирдлыг бууруулах бодлогын хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааг салбар дунд зохицуулан ажиллах, хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын албыг сайдын эрхлэх асуудлын хүрээнд 4 орон тоотойгоор байгуулсугай.

2. Сайдын дэргэдэх "Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажлын алба"-ны урсгал зардлыг хавсралтын ёсоор баталсугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар ханган ажиллахыг тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Цэнгэл, Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Р.Дэжид, нарт тус тус үүрэг болгосугай.

4. Ажлын албаны ажилтнуудын цалин болон урсгал зардлыг холбогдох хууль, журмын дагуу тооцож, Агаарын бохирдлыг бууруулах урсгал зардлаас гаргахыг Санхүү эдийн засгийн хэлтсийн дарга /О.Гантулга/, төсвийн ерөнхий нягтлан бодогч /Л.Оюунчимэг/ нарт зөвшөөрсүгэй.

САЙД



Н.БАТЦЭРЭГ

010006



АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Үндэсний хорооны гишүүдэд үүрэг
чиглэл хүргүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхий Сайдын 2014 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 151 дүгээр захирамжаар батлагдсан “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажиллах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1-д заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2015-2016 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

2. Монгол Улсын Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2016 оны төсвийн төлөвлөгөөгөө батлахаас өмнө орон нутгийн төсвийн хүрээнд агаарыг хамгаалах, бохирдлыг бууруулах арга хэмжээг төлөвлөн орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх, агаарын тухай хууль тогтоомж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан шийдвэрийн биелэлтийг нутаг дэвсгэртээ зохион байгуулж, хийсэн ажлын явц, үр дүнгийн талаар Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороонд сар, улирлаар танилцуулж байхыг Аймаг, Нийслэлийн Засаг дарга нар т үүрэг болгосугай.

3. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2015-2016 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө болон тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны Нарийн бичгийн дарга Р.Дэжидэд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА



Ч.САЙХАНБИЛЭГ



Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны
2015 оны 15/02 тоот тогтоолын хавсралт

**АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ
2015-2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Арга хэмжээ	Хугацаа,	Санхүүжилт	Хариуцах байгууллага
Нэг. Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох чиглэлээр хэрэгжүүлэх ажлууд				
1	Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны бүтэц бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах санал боловсруулах	IV улирал	Шаардлагагүй	АББҮХ
2	Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажиллах журамд нэмэлт өөрчлөлт оруулах	IV улирал	Шаардлагагүй	АББҮХ
3	Хөвсгөл аймгийн төв Мөрөн сумын агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх журмын төслийг батлах	IV улирал	Шаардлагагүй	БОНХАЖЯ
4	Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 309 дүгээр тогтоолоор батлагдсан урамшуулал олгох журамд нэмэлт өөрчлөлт оруулах	IV улирал	Шаардлагагүй	БОНХАЖЯ
5	Байгалийн хийн хангамжийн ашиглалтын норм, стандарт, дүрэм боловсруулах	Жилдээ	Шаардлагагүй	ЭХЯ
6	УИХ-аас баталсан "2015 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай" хуульд нийслэлийн гэр хорооллын айл өрхүүдэд олгож байсан цахилгааны үнийн урамшуулалд шаардагдах хөрөнгө тусгагдаагүй тул үүссэн асуудлын шийдлийг боловсруулах	IV, I улирал	Шаардлагагүй	ЭХЯ, НЗДТГ
7	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага. MNS 4585:2007 тоот стандартыг шинэчлэн батлуулах	Жилдээ	Шаардлагагүй	БОНХАЖЯ

8	Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах	IV, I улирал	Шаардлагагүй	БОНХАЖЯ
9	УБ Цэвэр агаар төсөл "Цэвэр зуух" -ны үндэсний стратеги эцэслэн боловсруулах	IV, I улирал	Шаардлагагүй	УБ-Цэвэр агаар төсөл
Хоёр. Судалгаа, шинжилгээний ажлууд				
10	Улаанбаатар хотын гэр хорооллын айл өрхийг хийн хэрэглээнд үе шаттайгаар шилжүүлэх боломжийг судлах	Жилдээ	Шаардлагагүй	ЭХЯ, УУЯ, НЗДТГ ШХААЭ-ийн холбоо
11	Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр гадаадын хөрөнгө оруулагчид болон олон улсын байгууллагаас дэмжлэг авч хамтран ажиллах санал боловсруулж танилцуулах	Жилдээ	Шаардлагагүй	АББҮХ
12	Хөтөлийн цемент, шохойн үйлдвэрийн үйл ажиллагааны явцад агаарт хаягдаж буй хүлэмжийн хий болон бусад хорт хаягдлын хэмжээг бууруулах чиглэлээр хийгдэх судалгааны ажил	Жилдээ	300 сая	УУЯ
13	Байгалийн хийн инженерийн сүлжээг байгуулах техник эдийн засгийн үндэслэлийг боловсруулах	Жилдээ	Шаардлагагүй	ЭХЯ
14	Агаар бохирдуулагч эх үүсвэрийн тооллого явуулах	Жилдээ	Шаардлагагүй	БОНХАЖЯ, НЗДТГ
Гурав. Салбар хороодод хийгдэх ажлууд				
15	Дүүрэг тус бүрт уурын болон усан халаалтын зуухны галч нарт сургалт зохион байгуулах	IV, I улирал	Шаардлагагүй	АББҮХ-ны Салбар хороод
16	Зуух хэрэглэж буй айл өрхүүдийн түлшний хэрэглээнд судалгаа хийх	II улирал	Шаардлагагүй	АББҮХ-ны Салбар хороод
17	Дүүргийнхээ ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон өндөр настан, иргэдэд агаарын бохирдлын талаар сургалт зохион байгуулах	Жилдээ	Шаардлагагүй	АББҮХ-ны Салбар хороод



АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 08

Улаанбаатар хот

Аймаг, нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Ерөнхий сайдын 2015 оны 247 дугаар захирамжаар баталсан “Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны ажиллах журам”-ын 4.1-д заасныг үндэслэн ТОГТООХ нь:

1. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд авч хэрэгжүүлэх арга хэмжээг 1 дүгээр, агаарын бохирдол ихтэй аймгуудын агаарын чанарыг сайжруулах бүсэд авч хэрэгжүүлэх арга хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Аймаг, нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсийг тогтоож, энэ тогтоолын хавсралтад заасан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулахыг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Н. Батцэрэг, холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам болон сайжруулсан түлш үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүдтэй Түлш нийлүүлэх тухай гурвалсан гэрээ байгуулж, сайжруулсан түлшээр айл өрхүүдийг хангах ажлыг зохион байгуулан борлуулалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга Э. Бат-Үүл, Баянгол дүүргийн Засаг дарга Д.Оросоо нарт даалгасугай.

4. Нийслэлийн сайжруулсан түлш хэрэглэх бүсэд орших 10.000 хүртэл айл өрхөд хөнгөлөлттэй үнээр түлш нийлүүлэх, түлш үйлдвэрлэгч аж ахуйн нэгжид нийлүүлсэн түлшний нэг тонн тутамд 52.500 (тавин хоёр мянга таван зуун) төгрөгийн татаас, сайжруулсан түлшийг эцсийн цэг дээр борлуулах, хадгалах, хяналт тавихад нэг тонн тутамд 12.500 (арван хоёр мянга таван зуун) төгрөгийн урамшуулал тус тус олгон, гэрээнд заасан нөхцөлийн дагуу санхүүжүүлэхийг Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын сайд Н. Батцэрэгт зөвшөөрсүгэй.

5. Гэр хорооллын айл өрхийн хэрэглээнд ялтсан халаагуурыг нэвтрүүлэх боломжийг судлан, уг халаагуурыг хэрэглэснээр гарах цахилгааны хэмнэлтийн тооцоог бэлтгэж танилцуулахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Эрчим хүчний яам, Эрчим хүчний хөгжлийн төвд тус тус даалгасугай.

6. Гурвалсан нано технологи бүхий шингэн НАНО бүтээгдэхүүнийг хэрэглээнд нэвтрүүлэх боломжийг судалж, саналаа танилцуулахыг Уул уурхайн яамны Төрийн нарийн бичгийн дарга Д. Артаг, Газрын тосны газрын дарга Г. Өлзийбүрэн нарт тус тус даалгасугай.

7. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хорооны Нарийн бичгийн дарга Р.Дэжид, Т. Бат-Эрдэнэ нарт үүрэг болгосугай.




МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА

A handwritten signature in black ink, written in a cursive style, overlapping the red stamp.

Ч.САЙХАНБИЛЭГ


Агаарын бохирдлыг бууруулах үндэсний
хорооны 2016 оны 23 тоот тогтоолын
Нэгдүгээр хавсралт



НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ БҮСЭД БАЙГАЛЬ ОРЧИН,
НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАРТАЙ ХАМТРАН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Үр дүн
Гэр хорооллын 10-12 мянган айл өрхийг боловсруулсан түлшээр хангах	I улиралд	2016.01.15-04.15 хүртэл 1 айл өрх 2тн орчим боловсруулсан түлш хэрэглэнэ гэж тооцов.
Гэр хорооллын 10 орчим мянган айлын хэрэглэж байгаа түүхий нүүрсийг нүүрс цэвэршүүлэгч бодисоор баяжуулах турших ажил	I улиралд	Зуухны яндангаас гарах бохирдуулагч бодис ялангуяа СО-ийн хэмжээг 50-70% бууруулах боломжтой.
Эхний ээлжид гэр хорооллын айл өрхийн цахилгаан хангамжийн найдвартай ажиллагааг дээшлүүлэх чиглэлээр их тойруугийн 110 кВ-ын дэд станцуудаас хэт ачаалагдсан 4 шугамын ачаалал хөнгөвчлөх угсралтын ажил	I-III улиралд	Их тойруугийн 110кВ-ын дэд станцуудаас хэт ачаалагдсан 4 шугамын ачааллыг хувааж шилжүүлэх ажлыг хийснээр Улаанбаатар хотын 4 дүүргийн 6000 айл өрхийн цахилгаан хангамжийн найдвартай ажиллагаа хангагдаж, цахилгаанаар халаах нөөц чадлыг бүрдүүлнэ.
Агаарын бохирдол ихтэй бүсэд байгаа цэцэрлэгүүдийн усан халаалтын зуухнуудыг шинэ дэвшилтэт технологид шилжүүлэх ажил	I-III улиралд	ЧД, 12-р хорооны 154-р цэцэрлэг, ЧД, 7-р хорооны 173-р цэцэрлэг, СБД, 18-р хорооны 166-р цэцэрлэг, СХД 9-р хорооны 38-р цэцэрлэг, СХД, 30-р хорооны 125-р цэцэрлэг; нийт 5 цэцэрлэгийн халаалтын зуухыг тус бүр нь 100,0 сая төгрөгөөр шинэчилнэ. Техникийн нөхцөл гарсан.
Нийтийн том оврын хуучин тээврийн хэрэгслүүдээс ялгарах агаар бохирдуулагч бодисыг бууруулах үр ашигтай шийдлийг судлах, тоосонцрын шүүлтүүр (DPF) суурилуулах боломжийг судлах, туршин нэвтрүүлэх	I-III улиралд	Нийтийн том оврын хуучин тээврийн хэрэгслүүдээс ялгарах тоосонцорыг бууруулах тоног төхөөрөмжийн судалгааг хийж, улмаар суурилуулан турших замаар үр ашиг, зардлын тооцоог гаргана.

Агаарын бохирдлыг бууруулах үндэсний
хорооны 2016 оныг 03 тоот тогтоолын
хоёрдугаар хавсралт



АГААРЫН БОХИРДОЛ ИХТЭЙ АЙМГУУДЫН АГААРЫН ЧАНАРЫГ САЙЖРУУЛАХ
БҮСЭД БАЙГАЛЬ ОРЧИН, НОГООН ХӨГЖИЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ, АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТАЙ ХАМТРАН АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

№	Аймгийн нэр	Хугацаа	Хийх ажил
1	Хөвсгөл	I-III улиралд	Агаар дахь тоосонцрыг хэмжих багаж хэрэгсэл, бусад тоноглолын хамт /интернет модем, путик, цахилгаан халаагуур, хөргүүр, бусад тоноглолын хамт/
2	Өвөрхангай	I-III улиралд	Аж ахуйн нэгж, байгууллагуудыг нэгдсэн халаалтын системд холбох шугам хоолойн угсралтын ажил
		I-III улиралд	Аймгийн төвийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 16 том оврын халаалтын зуухны янданд шүүлтүүр тавих.
3	Өмнөговь	I-III улиралд	500 айл өрхөд сайжруулсан зуух хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх
4	Баянхонгор	I-III улиралд	Агаар дахь тоосонцрыг хэмжих багаж хэрэгсэл, бусад тоноглолын хамт /интернет модем, путик, цахилгаан халаагуур, хөргүүр, бусад тоноглолын хамт/
		I-III улиралд	500 айл өрхөд сайжруулсан зуух хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх
5	Дархан-Уул	I-III улиралд	500 айл өрхөд сайжруулсан зуух хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх
6	Орхон	I-III улиралд	Агаарын чанарыг сайжруулах хязгаарлалтын I бүсэд сайжруулсан зуух аваагүй үлдсэн 1500 айл өрхийг зуухаар хангах.
7	Ховд	I-III улиралд	1500 айл өрхөд сайжруулсан зуух хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх.



АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ТОГТООЛ

2014 оны 04 сарын 25 өдөр

Дугаар 05

Улаанбаатар хот

Сайжруулсан түлшний чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай

Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1¹, Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны ажиллах журмын 3 дугаар зүйлийн 3.3, 5.1-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Сайжруулсан түлш үйлдвэрлэх хөрөнгө оруулалтаа бие даан шийдсэн, технологи нь үйлдвэрлэлд нэвтэрсэн, холбогдох стандартын шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх санал ирүүлсэн аж ахуйн нэгжүүдтэй 2014-2015 оны халаалтын улиралд сайжруулсан шахмал түлшний нэг тонн тутмын үнийг заагдсан цэг нөхцлөөр 125.000 (Нэг зуун хорин таван мянган) төгрөгөөс хэтрэхгүй байхаар бүтээгдэхүүн худалдан авах гэрээ байгуулан ажиллахыг Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга /Ж.Эрдэнэцогт/-д, гэрээний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч /Т.Бат-Эрдэнэ/-д, уг ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх захирал /Д.Баасан/-д тус тус даалгасугай.

2. Сайжруулсан түлшийг хадгалах, тээвэрлэх, борлуулах аж ахуйн нэгжүүдийг холбогдох хуулийн хүрээнд сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллахыг Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга /Ж.Эрдэнэцогт/-д, гэрээний хэрэгжилтийг зохион байгуулж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч /Т.Бат-Эрдэнэ/-д, уг ажлыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг санхүүжүүлэхийг Цэвэр агаарын сангийн гүйцэтгэх захирал /Д.Баасан/-д тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2014 оны 5 дугаар сарын 12-ний өдрийн 4 дүгээр тогтоолын 1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний хорооны Нарийн бичгийн дарга /Ж.Эрдэнэцогт/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Н.АЛТАНХУЯГ